

ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ УЛСЫН НӨӨЦ, ТҮҮНИЙ УДИРДЛАГАД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

П.Даш¹, Х.Мягмаржав², Ц.Баясгалан³, Н.Одмаа⁴, ¹ОБЕГ-ын Гамшиг судлалын хүрээлэнгийн нөөц судлалын төвийн дарга, доктор, профессор, хошууч генерал
²ДХИС-ийн ОБС-ийн Эдийн засаг-нөөц, ар талын тэнхимийн эрхлэгч, доктор, дэд профессор, дэд хурандаа
³ДХИС-ийн ОБС-ийн Эдийн засаг-нөөц, ар талын тэнхимийн ахлах багш, доктор, дэд профессор
⁴ДХИС-ийн ОБС-ийн Эдийн засаг-нөөц, ар талын тэнхимийн багш, дэслэгч

Хураангуй

Улсын нөөц нь үндэсний эдийн засгийн хөгжлийг тэнцвэржүүлэх, тогтворжуулах, эдийн засгийг хөгжүүлэх нийгэм эдийн засгийн төлөвлөгөөнд тооцоологдоогүй онцгой нөхцөл байдалд ашиглах материал баялгийн сэлбэх нөөцөөр тодорхойлогддог. Улсын нөөцийн удирдлага нь зах зээлд үндэсний эдийн засгийг дайчлах, эдийн засгийг тэнцвэржүүлэх, тогтвортой хөгжлийг хангах зорилгоор улсын нөөцийг бүрдүүлэх, байршуулах, хадгалах, хамгаалах, ашиглах, нөхөн бүрдүүлэх, үйлчлэх эдийн засаг, захиргаа, хэм хэмжээ-эрх зүйн арга хэмжээний цогц билээ. Улсын нөөцийн үүрэг, зорилго, улсын нөөцийн удирдлагын тогтолцоо, үүрэг тухайн улсын төрийн байгууламж, хөгжлийн түвшин, байгалийн нөөц, баялаг, хүн амын хэрэгцээ, гамшиг ослын нөхцөл байдал зэргээс шууд хамааралтай болох нь судалгааны ажлын явцад харагдсан.

Иймд Монгол Улсын нөөцийн төрөл, хэлбэр, зорилго, түүний удирдлагын үүрэг, зорилтыг олон улсын жишигт нийцүүлж шинжлэх ухааны үндэстэй тодорхойлж, цаашид боловсронгуй болгохын тулд улсын нөөц ба түүний удирдлагын өнөөгийн байдалд шинжилгээ хийж Гадаадын зарим орны улсын нөөц, түүний удирдлагад хийсэн шинжилгээтэй харьцуулан дүгнэлт хийх замаар улсын нөөцийн бүтэц, тогтолцоо, удирдлагыг боловсронгуй болгох арга замыг сайжруулах шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа талаар онол арга зүй болон туршлагыг илүү дэлгэрүүлэн судлах хэрэгтэй гэж судалгааны ажлаараа дүгнэлээ.

Түлхүүр үг: Улсын нөөцийн удирдлага, улсын нөөц, улсын нөөцийн бүтэц, тогтолцоо

Танилцуулга

Улсын нөөцийн талаар янз бүрийн тодорхойлолт, ойлголттой тааралдаж болно. Гэхдээ дэлхийн улс орнуудын улсын нөөцийн нийтлэг үүрэг, зорилгыг

улсын нөөцийн тухай тодорхойлолт судлан шинжилж үзэхэд Монгол Улсын нөөцийн тухай хуульд тодорхойлсон тодорхойлолт илүү оновчтой болох нь харагдаж байна. Уг хуульд —Улсын нөөц|| гэж нийгэм, эдийн засгийг тогтвортой байлгах, үндэсний аюулгүй байдал, хүн амыг хангахад зориулагдах болон гамшиг, эдийн засгийн хүндрэл бэрхшээл, дайны байдал зэрэг онцгой байдлын үед гамшгийн хор уршгийг арилгах,

эдийн засгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор зах зээл дэх зарим бараа, материалын эрэлт, нийлүүлэлтийн харьцааг тэнцвэржүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор, улсын нөөцөд эргэн төлөгдөх болон буцалтгүй тусламж болгон улсын нөөцөд эргэн төлөгдөхгүй нөхцөлөөр ашиглахын тулд нөөцлөн хадгалж буй бараа, материалыг хэлнэ ¹ хэмээн тодорхойлсон байна.

Улсын нөөцийн тухай онол, арга зүй

Улсын материаллаг нөөцийг бий болгоход нөлөөлсөн олон хүчин зүйлээс шалтгаалж улсын нөөцийн хөгжил нь хэд хэдэн үе шатыг дамжжээ.

Улсын нөөц нь үндэсний эдийн засгийн хөгжлийг тэнцвэржүүлэх, тогтворжуулах, эдийн засгийг хөгжүүлэх нийгэм эдийн засгийн төлөвлөгөөнд тооцоологдоогүй онцгой нөхцөл байдалд ашиглах материал баялгийн сэлбэх нөөцөөр тодорхойлогддог байна.

Улсын нөөцийн зорилгыг нарийвчлан тодорхойлбол:

- Үндэсний аюулгүй байдлыг хангах,
- Үндэсний эдийн засгийн хөгжлийг тэнцвэржүүлэх,
- Нийгэм, эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөөнд тооцоологдоогүй онцгой нөхцөл

байдалд ашиглах,

- Гамшгийн хор уршгийг арилгах, сэргээн босгох,
- Улсын дайчилгааны бэлэн байдлыг хангах. зэрэг болно. Улсын нөөц нь хоёр хэлбэртэй байна. Үүнд:

❖ Материаллаг нөөц- энэ нөөцийг манай улсад ОБЕГ удирдаж байна. Гадны бусад орнуудад нөөцийн барааны нэр төрөл, зориулалтаасаа хамаараад янз бүрийн байгууллагад харъяалагдсан байдаг.

❖ Мөнгө санхүүгийн нөөц – энэ нь Монгол Улсын Засгийн Газрын нөөцөд байдаг. Бусад улс оронд засгийн газраас гадна хувийн хэвшлийн салбарт харъяалагдсан байх нь бий.

Улсын материаллаг нөөцийг зориулалтаар нь стратегийн болон гамшгийн үеийн нөөц, түвшингээр нь улсын болон орон нутгийн нөөц гэж ангилна.

Улсын нөөцийн удирдлага гэдэг нь зах зээлийн нөхцөлд үндэсний эдийн засгийг дайчлах, эдийн засгийг тэнцвэржүүлэх, тогтвортой хөгжлийг хангах зорилгоор улсын нөөцийг бүрдүүлэх, байршуулах, хадгалах, хамгаалах, ашиглах, нөхөн бүрдүүлэх, үйлчлэх эдийн засаг, захиргаа, хэм хэмжээ-эрх зүйн арга хэмжээний цогц юм. Улсын нөөцийн удирдлагын үүрэг нь:

1. Улсын нөөцийг бүрдүүлэх, байршуулах, хадгалах, хамгаалах, ашиглах, нөхөн бүрдүүлэх, үйлчлэх ажиллагааг:

- Төлөвлөх,
- Зохион байгуулах
- Зохицуулах
- Хянаж шалгах /дотоод хяналт/
- Хүний нөөцийг бүрдүүлэх.

2. Улс орны нийгэм эдийн засгийн хөгжилд нөлөөлөх улсын нөөцийн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор улсын нөөцийн бараа материалын нөөцийг худалдан авах, хуваарилах, тээвэрлэх, хадгалах, үйлчлэх талаар удирдлагын шийдвэрийг:

- Боловсруулах,
- Батлуулах,
- Хэрэгжилтийг зохион байгуулах явдал юм.

Олон улсын харьцуулалт судалгаа

Дэлхийн улс орнууд өөр өөрийн онцлог, эдийн засгийн хөгжил, эрсдэлээсээ хамаараад улсын нөөцийг бүрдүүлж байгаа бараа бүтээгдэхүүн, тэдгээрийн зориулалт, тоо хэмжээ нь өөр өөр байна. Тэдгээрт задлан шинжилгээ хийж хооронд нь харьцуулан судаллаа. Үүнд:

➤ Бельги Улс:

Хүнсний бүтээгдэхүүн (сүүн бүтээгдэхүүн, мах, загас, үр тариа, элсэн чихэр, хүнсний ногоо) нөөцөлдөг. Үндсэн зорилт нь зарим төрлийн бараа бүтээгдэхүүнээр зах зээлд нөлөө үзүүлдэг зохицуулалтын үүргийг гүйцэтгэх явдал юм. Улсын нөөцийн байгууллагыг нь Бельгийн интервенц, нөхөн сэргээлтийн товчоо (BIRB) гэдэг. *Байгууллагын нэр болон улсын нөөцийн зорилгоос харахад улсын нөөц нь зах зээлд нөлөөлөх замаар эдийн засгаа тогтворжуулах зорилготой байдаг ба тус улсын хувьд хүнсний аюулгүй байдал, хангалтын асуудал анхаарал татсан гол асуудлын нэг байдаг бололтой.*

➤ Бенин Улс:

Гал тогооны хэрэгсэл, хүнсний зүйл, хувцас, гудас, ноосон хөнжил нөөцөлдөг. Гол эрхэм зорилго нь гамшиг ослын үед онцгой байдлын аврах ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих явдал юм. Улсын нөөцийн байгууллага нь Иргэний хамгаалалтын үндэсний хороо (CNPC) юм. Тус улс нь Африкийн буурай хөгжилтэй улсын ангилалд ордог, ерөнхийлөгчийн засаглалтай улс юм² *Хөгжил буурай улс учраас эдийн засгийг тогтворжуулах, зах зээлд нөлөөлөх хүчин чадал дутмаг учраас гамшиг ослын үед хүн амаа хамгаалахад*

➤ ХБНГУ:

Түүхий газрын тосны бүтээгдэхүүн (бензин, дизель түлш, газрын тосны хөнгөн бүтээгдэхүүн, тийрэлтэт түлш, мазут) нөөцөлдөг. Германы хойд хэсэгт орших түүхий тос хадгалах зориулалттай 8 бүлэг давсан агуулахаас бүрдсэн агуулахын цогцолбортой. Газар дээрх агуулахаа бэлэн болсон газрын тосны бүтээгдэхүүнээ хадгалахад ашигладаг. Одоогийн байдлаар 250сая баррель түүхий болон бэлэн болсон газрын тос хадгалагдаж байна. Энэ нь Европ дахь хамгийн том нөөц юм. Улсын нөөцийн удирдлагыг Нөөцийн удирдлагын үндэсний агентлаг (EBV) хэрэгжүүлдэг. *Эдийн засаг нь хүчирхэгжсэн учраас эдийн засгийг тогтворжуулах, зах зээлийг дэмжихэд газрын тосноос өөр төрлийн нөөц шаардлагагүй гэж үзсэн бололтой. Харин европын холбооны улсын хувьд хамгийн их нөөцтэй, газрын тосны бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх боломжтой хүчин чадалтайн хувьд өөрийн орныг хангаад зогсохгүй европын холбооны бусад улсуудад тусламж үзүүлэхэд бэлэн байх зорилгоор түүхий болон боловсруулсан газрын тосны бүтээгдэхүүн нөөцөлдөг гэсэн дүгнэлтэд хүрлээ.*

➤ Дани Улс:

Газрын тос ба байгалийн хий нөөцөлдөг. Байгалийн хийн 2 агуулахтай:

1. Стенлиллед (хий нь 1500 м-ийн гүнд сүвэрхэг элсэн чулуун давхаргад хадгалагддаг)

2. Лилль Торупт-д (1000-1700 м-ийн гүнд, 7 том гүний уурхай, 200-300 м өндөр, 40-60 м диаметртэй) байдаг. Газрын тосны бүтээгдэхүүний нөөц нь 1,4 сая тн (батлан хамгаалах нөөц ороогүйгээр) *Инфляц бага 2,4%, ажилгүйдэл 5% байгалийн хий, газрын тосны нөөц ихтэй, өндөр технологийн хүчтэй, ашигтай үйлдвэрлэлтэй, ажиллах хүчний ур чадвар сайтай учраас улс орны хөгжил тогтвортой байдаг.*³ *Иймд батлан хамгаалах нөөцөөс гадна ахуйн хэрэгцээнд болон үйлдвэр үйлчилгээнд зориулж газрын тос, байгалийн хийг нөөцөлдөг гэж үзэж болохоор байна.*

➤ **Замби Улс:**

Үр тариа (цагаан будаа, эрдэнэ шиш) нөөцөлдөг. Улсын нөөцийн Хүнсний нөөцийн агентлаг удирддаг. Энэ нь үндэсний хүнсний нөөцийг удирдах үүрэгтэй хагас бие даасан корпорац юм. Үндсэн үүрэг нь:

- үндэсний хүнсний нөөцийг удирдах,
- бүтээгдэхүүний эрэлт, зохистой борлуулалтыг судлах,
- зах зээлд туслалцаа үзүүлэх,
- агуулахуудыг удирдах явдал байдаг.

Эдгээрээс үзэхэд тус улсын нөөц нь зах зээлийг тогтворжуулах, хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангалтын хэвийн хэмжээнд барьж байх, үүний тулд маш нарийн судалгаан дээр тулгуурласан удирдлага явуулдаг болох нь харагдаж байна.

➤ **БНЭУлс:**

Түүхий газрын тос, Үр тариа (улаан буудай, цагаан будаа) нөөцөлдөг. Түүхий газрын тосны стратегийн нөөцийг газрын тосны компаниудын одоо байгаа түүхий тос, бэлэн тосны бүтээгдэхүүний нөөцөөс гадна бий болгосон байдаг. Энэхүү төсөл нь 2012 он хүртэл хэрэгжихээр тооцсон. Мангалор, Падур, Висакхапатнам дахь гурван гүний агуулах байгууламжийг багтаасан, нийт хэмжээ 37.4 сая баррель буюу 5,9 сая тн байна. Үүнийг Энэтхэгийн газрын тосны стратегийн нөөцийн компани (ISPRL) удирддаг. Харин Үр тариа (улаан буудай, цагаан будаа)-ны нөөцийг Энэтхэгийн хүнсний корпорац (FCI) удирддаг. FCI 1965 байгуулагдсан төрийн өмчит корпорац юм. Төв нь Шинэ Дели-д байдаг. Бүрэлдэхүүнд нь бүсийн 5, орон нутгийн 26 салбар багтдаг. Тус корпорац нь улс даяар байрладаг агуулахын өргөн сүлжээг эзэмшдэг. FCI-ийн дэмжлэгтэйгээр Хүнсний аюулгүй байдлын хүрээлэнг байгуулан ажиллуулж байна.

Үүнээс үзэхэд дэлхийд хүн амын тоогоор тэргүүлэгч улсын нэг болох Энэтхэг Улс нь хүн амын хүнсний хангалт, түүний аюулгүй байдалд ихээхэн анхаарч хүнсний гол нэр төрлийн бүтээгдэхүүн болсон буудай, цагаан будааг нөөцөлдөг ба төр мэргэшсэн удирдлагаар хангаж байх үүднээс үр тарианы нөөцөө төрийн өмчит хүнсний корпорацийн удирдлагад байлгадаг.

Аливаа улс орон зам тээвэр, халаалт, дулааны эх үүсвэр болсон газрын тосны бүтээгдэхүүнийг стратегийн гол нөөцөө болгодгийн жишгээр тус улс газрын тосны бүтээгдэхүүнийг их хэмжээгээр нөөцөлдөг ба шинжлэх ухаанч мэргэжлийн удирдлагад онцгой анхаар уг нөөцийг Энэтхэгийн газрын тосны стратегийн нөөцийн компанид удирдуулсан байна.

Үүнээс улсын төсөвт дарамт учруулахгүйгээр улсын нөөцийг баталгаатай бүрдүүлж, төрийн зохицуулалттай, шинжлэх ухаанч, мэргэжлийн удирдлагаар хангаж байхын тулд улсын нөөцийг судалгаа шинжилгээний байгууллага бүхий төрийн өмчит компаниар удирдуулдаг болох нь харагдаж байна.

➤ **Иран Улс:**

Түүхий газрын тос нөөцөлдөг. 2006 оноос эхлэн түүхийн газрын тосны

стратегийн нөөцийг бий болгосон. Нийт 10 сая баррель багтаамжтай агуулахыг 5 хотод байгуулсан. Харг арал дээр 4 сая баррелийн багтаамжтай 4 сав нэмж байгуулсан. Үүнийг Ираны үндэсний газрын тос ба байгалийн хийн компани (NIOC) удирддаг. Энэ нь Төрийн өмчит компани. *Иран Улсын хувьд газрын тос, байгалийн хийн асар их нөөцтэй атлаа зөвхөн газрын тос, байгалийн хийн улсын нөөцийг бүрдүүлж байгаа нь улс орны эдийн засгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор өөрийн оронд хамгийн их байдаг, дэлхийн зах зээлд хамгийн их эрэлт*

хэрэгцээтэй байгаа түүхий эд бүтээгдэхүүнийг нөөцөлдөг гэсэн дүгнэлтэд хүрч болохоор байна.

➤ **Итали Улс:**

Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн, байгалийн хий хадгалдаг. Улсын газрын тосны нөөц нь Милацца (Сицили), Гаета (Ромын өмнөд хэсэг), Вольпиано (Туриний ойролцоо) газарт хадгалагдаж байна. Хадгалалтын хэмжээ нь ойролцоогоор 7-8 сая баррель юм. Улсын нөөцийг Үндэсний нүүрс-ус төрөгчийн төрийн өмчит компани (ENI) удирддаг. *Итали нь зохих хэмжээний газрын тос болон байгалийн хийх нөөцтэй хэдий ч эрчим хүчнийхээ нөөцөөр улсынхаа нийт эрчим хүчний хэрэгцээний дөнгөж 15%-ийг хангадаг. Иймд эрчим хүчний эх үүсвэрээ найдвартай хангах зорилгоор газрын тосны бүтээгдэхүүн болон байгалийн хийг нөөцөлдөг гэж үзэж болохоор байна. Ирантай адилхан нэр төрлийн бүтээгдэхүүн нөөцөлдөг ч гэсэн зориулалт нь өөр байгааг эндээс харж болно.*

➤ **Кени Улс:**

Үр тариа нөөцөлдөг. Үүнийг Үр тариа, бүтээгдэхүүний үндэсний зөвлөл (NCPB) удирддаг бөгөөд Энэ нь 1979 онд байгуулагдсан Хөдөө аж ахуйн яаманд захирагддаг төрийн өмчит корпорац юм. Бүтцэд нь 110 газар доорх агуулах, болон агуулах, албан өрөө, туслах байгууламжийн сүлжээ, боловсруулагдаагүй газар багтдаг. Нийт хадгалалтын багтаамж - 1.8 сая тонн байдаг. *Кени нь газар тариалангийн орон тул хангалттай хэмжээний үр тариа нөөцлөх боломжтой юм. Гэхдээ хүнснийхээ дотоодын хэрэгцээг бүрэн хангаж чаддаггүй учраас БНХАУ, Энэтхэг, Эмират, Саудын Араб зэрэг улсаас гол нэрийн бүтээгдэхүүнээ импортоор авдаг. Үүнээс үзэхэд хүн амын хүнсний хангалтыг тасалдуулахгүй байх үүднээс үр тариа нөөцөлдөг гэсэн дүгнэлт хийж болохоор байна.*

➤ **БНХАУ:**

Дөрвөн төрлийн нөөцтэй. Үүнд, гамшгаас хамгаалах нөөцөд нь майхан, ноосон хөнжил, аврах дэлгэц, хүмүүсийг бусад тоног төхөөрөмж, хоол хүнс байдаг бөгөөд энэ нь Иргэний хэргийн яаманд харъяалагддаг. Харин бусад гурван нөөц нь БНХАУ-ын Хөгжил, шинэчлэлтийн яаманд харъяалагддаг Материаллаг нөөцийн улсын хороо Тэсрэх бодис, металл (зэс, төмөр), нефтийн бүтээгдэхүүн (түүхий тосноос бусад)-ий, Үр тарианы асуудал эрхлэх ерөнхий газар Үр тарианы, газрын тосны стратегийн нөөцийн газар түүхий газрын тосны нөөцийг тус тус хариуцдаг. *БНХАУ сүүлийн 30 жилийн хугацаанд хүнд үйлдвэр ба технологид үсрэлт хийсэн, эдийн засгийн өсөлтөөр дэлхийн тэргүүлэгч орны нэг болсон, ашигт малтмалын нөөцөөр дэлхийд 3-рт ордог ба дэлхийн нийт баялгийн 12% орчим нь Хятадад байдаг, 2002 оноос хойш хилийн чандад хөрөнгө оруулах асуудал үлэмж нэмэгдсэн⁴ зэргийг улсын нөөцийн нөр төрөлтэй харьцуулан дүгнэж үзэхэд улсын*

⁴ <https://ru.wikipedia.org/wiki/китай>

нөөц нь өөрийн орны төдийгүй бүс нутгийн тогтвортой хөгжлийг хангах, гамшиг ослоос сэргийлэх, хор уршгийг арилгах, сэргээн босгоход голчлон чиглэжээ гэж үзэхээр байна. Түүнээс гадна шаардлагатай үед батлан хамгаалах хүчээ зузаатгах, шинэ төрлийн зэвсэг техник үйлдвэрлэх, шинэ технологи нэвтрүүлэхэд зориулсан нөөцтэй гэж дүгнэж болохоор байна.

➤ **Шинэ Зеланд Улс:**

Газрын тос, байгалийн хий, ашигт малтмал, нүүрсний нөөцтэй бөгөөд төв агуулах нь Веллингтон хотын ойролцоо байрладаг. Үүнийг Шинэ Зеландын газрын тос, ашигт малтмалын газар хариуцдаг. Энэхүү төрийн байгууллага нь Шинэ Зеландын эдийн засгийн хөгжлийн яамны бүрэлдэхүүнд байдаг. 2010 онд Эзэн хааны Ашигт малтмалын үл хөдлөх хөрөнгийн газрын оронд газрын тос, ашигт малтмалын нөөцийг эзэн хааны нэрийн өмнөөс удирдах зорилгоор байгуулагдсан. Төв агуулах нь Веллингтон хотын ойролцоо байрладаг. *Шинэ Зеланд Улс нь газрын тос, байгалийн хий, нүүрс, алт мөнгөний олборлолтдоо ихээхэн анхаардаг.⁵ Эрчим хүчний эх үүсвэрийн үндсийг атомын энергээс гадна газрын тосны бүтээгдэхүүн, байгалийн хий, нүүрс бүрдүүлдэг байна. Иймд тус улс нь газрын тосны бүтээгдэхүүн, байгалийн хий, нүүрс нөөцөлдөг. Алт, мөнгө зэрэг үнэт металлууд нь эдийн засгийг тогтворжуулах хэрэгсэл болдог. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, загас, далайн болон ойн бүтээгдэхүүн экспортын үндсийг бүрдүүлдэг бол газрын тос, нүүрс зэрэг нь импортын гол бүтээгдэхүүн болдог. Үүнээс үзвэл улсын нөөцийн нэг гол хэсэг болсон газрын тос, нүүрс нь тухайн улсын эдийн засгийг тогтворжуулах, аюулгүй байдлыг хангах зорилготой болох нь харагдаж байна.*

➤ **АНУ:**

Холбооны нөөцийн сангаас гадна Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн болон Газрын тосны талбайг нөөцөлдөг. Үүнийг Холбооны Газрын тосны стратегийн нөөц (SPR)-ийн газар удирддаг. Уг нөөц нь Газрын тосны нөөцлөгдсөн 6 талбайгаас бүрдсэн улсын фонд хэлбэрээр 1912 онд байгуулагдсан. Арабын газрын тосны хоригийн дараагаар 1973-1974 онд эдгээр газрын тосны талбайгаа ашиглаж эхэлсэн. 1923 онд Аляскад 3-6 млрд баррель нөөцтэй үндэсний газрын тосны нөөцийг байгуулсан. SPR нь 1975 онд зохион байгуулагдсан. 677 сая баррелийн багтаамжтай чулуулгийн давсны ордын 4 агуулахтай. 2000 онд 2 сая баррелийн багтаамжтай орон сууцны халаалтын зориулалттай халаалтын түлшний зүүн хойд бүсийн нөөцийг байгуулсан. Түүнээс гадна Онцгой байдлын үеийн нөөцтэй. Үүнийг Холбооны онцгой байдлын агентлагийн Материал техникийн хангалтын төв удирддаг. Энэ нь материал техникийн хангалтын 11 төвтэй (Атлант, Берривилле, Камберленд, Форт-Уэрте, Фредерике, Сан-Хосе и на островах Гуам, Гавайи и Пуэрто-Рико),

¹¹

⁵ https://ru.wikipedia.org/wiki/новая_Зеландия

эмнэлгийн хэрэгсэл тоног төхөөрөмж бүхий 50 агуулахтай. *АНУ нь бусад улсын нэгэн адил газрын тос, үр тарианы стратегийн нөөцтэй бөгөөд газрын тосны талбай, тариа тарих үржил шимтэй газрыг нөөцөлдгөөрөө онцлогтой байна. Энэ нь ч ашиг тусаа өгч байсан туршлага, сургаамжтай юм. Зориулалтын хувьд зөвхөн өөрийн орны аюулгүй байдлыг хангахаас гадна бусад улсад тусламж дэмжлэг үзүүлэхэд зориулагдсан учраас асар их хэмжээний материаллаг болон санхүүгийн нөөц*

бүрдүүлэхэд хүргэдэг байна. Үүнийг их гүрний онцлог гэж үзэж болох юм. Мөн гамшигаас хамгаалах нөөцийг бүрдүүлэхэд ихээхэн анхаардаг бөгөөд энэ нь тус улсын нутаг дэвсгэрт байнга шахам тохиолддог далайн хар салхи мэт гамшигтай холбоотой байна.

➤ **Франц Улс:**

Газрын тосны бүтээгдэхүүн (бензин, агаарын тээврийн керосин, дизель түлш, тийрэлтэт түлш, бойлерийн түлш, мазут)-ий нөөцтэй. Маноск хотод нийт 41 сая баррель багтаамжтай 48 давсны агуйгаас бүрдэх газрын тос хадгалах агуулахын цогцолбортой. Улсын нөөцийг Стратегийн нөөцийг удирдах мэргэжлийн хороо (CPSSP) удирддаг. Франц нь төмрийн болон ураны хүдэр, газрын тос, зэс, цайрын их баялагтай, эрчим хүчний үйлдвэрлэлдээ жилд 220 сая тн төрөл бүрийн түлш хэрэглэдгийн дөрөвний гурвыг нь атомын энерги эзэлдэг. Гэвч 41 сая баррель газрын тос нөөцөлж⁶ байгаагийн дээр нүүрс болон газрын тосыг их хэмжээгээр импортоор авдгаас үзэхэд эдгээр баялгаа байгальд нь нөөцөлж байна гэж үзэж болохоор байна.

➤ **БНСУ буюу Өмнөд Солонгос Улс:**

Түүхий газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн, шингэрүүлсэн хий нөөцөлдөг. Нийт хадгалах хэмжээ нь 141 сая баррель түүхий тос, газрын тосны бүтээгдэхүүн юм. Шингэрүүлсэн хийн газар доорх хэд хэдэн агуулахтай (хамгийн том нь 360,000 тоннын хүчин чадалтай). Үүнийг Солонгосын үндэсний газрын тосны корпораци (KNOC) удирддаг. Газрын тосны бүтээгдэхүүн тээврийн хэрэгсэл, эрчим хүчний салбарт өргөн хэрэглэгддэг бөгөөд энэ төрлийн бүтээгдэхүүн ховортой учраас 17 сая тн газрын тосны бүтээгдэхүүн нөөцөлсөн байна. Өөрөөр хэлбэл энэхүү нөөцийг аюулгүй байдлаа хангахад чиглэгдсэн гэж үзэж болохоор байна.

➤ **Япон Улс:**

Газрын тос, шингэрүүлсэн хий, газрын ховор элемент нөөцөлдөг. Үүнийг Японы газрын тос, хий, металлын үндэсний корпорац (JOGMEC) удирддаг. Энэ нь татан буугдсан Японы үндэсний газрын тосны корпорац (1978 оноос хойш үйл ажиллагаагаа явуулж, зөвхөн түүхий тос хадгалдаг байсан), Японы Металлын хүдэр боловсруулах агентлаг (1973 оноос хойш үйл ажиллагаагаа явуулдаг байсан, өнгөт металл болон бусад ашигт малтмалын нөөцийг хариуцдаг байсан) чиг үүргийг нэгтгэж 2004 онд байгуулагдсан. Энэ нь 324 сая баррель

⁶ <https://ru.wikipedia.org/wiki/франция>

газрын тосны багтаамжтай 10 агуулах, 1.5 сая тонн багтаамжтай 5 хийн агуулах болон 37,000 м2 талбай бүхий металл агуулахтай. Япон улс ашигт малтмал ховортой. Газрын тосны бүтээгдэхүүн багд хэмжээгээр олборлодог. Жилд 16-17 мянган тн газрын тос олборлодог. Харин газрын ховор элементийн олборлолтоор дэлхийд 6-рт ордог. Үүнээс үзэхэд Японы улсын нөөц нь эдийн засгийн аюулгүй байдлаа хангах, эдийн засгаа тогтворжуулахад чиглэсэн гэж үзэж болохоор байна. Эдгээр улсуудын улсын нөөцийн тухай мэдээллийг холбогдох сайтаас авав.⁷

Судалгааны харьцуулалтын үр дүн

Бид судалгааны ажлын сэдвийн хүрээнд улсын нөөцийн удирдлага хэрхэн явагддаг тухай хэд хэдэн улсын жишээн дээр авч үзэж задлан шинжилсэн.

➤ Франц Улс:

Францын улсын нөөцийг хадгалдаг байгууллага нь SAGESS⁸ (Аюулгүй байдлын нөөцийн удирдлагын компани гэсэн утгатай Франц үгийн товчлол) нь 1988 онд газрын тосны үйлдвэрлэгчдийн санаачлагаар, засгийн газрын агентлагуудын ивээл дор байгуулагдсан, үндэсний болон олон улсын стандартад нийцсэн үүргээ биелүүлэхийн тулд газрын тосны стратегийн нөөцийг бүрдүүлэх, нөөцлөх, хадгалах үүрэгтэй байгууллага юм. SAGESS нь 1992 онд байгуулагдсан Газрын тосны стратегийн нөөцийн мэргэжлийн хороо буюу CPSSP⁹ гэдэг байгууллагаас бүрэн эрх нь зөвшөөрөгдсөн байгууллага юм.

Газрын тосны бүтээгдэхүүний үндэсний хэмжээний стратегийн нөөцийн үлэмж хэмжээний хувийг байнга барьж байх, энэ нь санхүүгийн зах зээлтэй тогтмол холбогдож байхыг шаарддаг, үүний тулд логистикийн болон санхүүгийн механизм дээр тулгуурлах зайлшгүй шаардлагатай болдог зэрэг нь газрын тосны бүтээгдэхүүний стратегийн нөөцийг удирдан зохицуулах үйл ажиллагааг улам нарийн төвөгтэй болгодог байна.

Франц Улс нь 1990-ээд оноос эхлээд газрын тосны стратегийн нөөцийн анхдагч нь болсон байна. Газрын тосны бүтээгдэхүүний стратегийн нөөцийн талаарх энэ бодлогыг Франц болон Европын холбоо бага зэргийн засвар хийн мөрдөн ажиллаж байна. Газрын тосны бүтээгдэхүүний стратегийн нөөцийн 73.9%-ийг газрын тос үйлдвэрлэгч компаниуд өөрийн хувьцаагаар хангаж байгаа бөгөөд хувьцааг зах зээлд гаргах асуудлыг зөвхөн Францын эрчим хүчний яам шийдвэрлэдэг. Үүний үр дүнд Аюулгүй байдлын нөөцийн удирдлагын компани нь дараах механизмыг бүрдүүлж чадсан байна.

- Хямрал гарсан үед эсвэл Газрын тосны стратегийн нөөцийн мэргэжлийн хорооны хүсэлтээр Францын засгийн газрын эрх бүхий байгууллагад хувьцаагаа өгнө.

⁸ <https://www.sagess.fr/en/profile/about-sagess/overview>

⁹ <https://www.sagess.fr/en/profile/about-sagess/cpspp>

- Зайлшгүй тохиолдолд нийтийн хэрэгцээнд хувьцааг гаргахдаа цаг тухайд нь зохицуулалт хийнэ.

- Хадгалах байгууламжийн хангалттай сүлжээгээр дамжуулан улс орон даяар тэдгээрийн хүртээмжтэй байдлыг баталгаатай болгоно.

- Хувьцааны санхүүжилтийн оновчтой, тогтвортой байдлыг хангана.

Ийнхүү Францын Улсын нөөцийн үндсийг зөвхөн газрын тосны бүтээгдэхүүний стратегийн нөөц бүрдүүлж байгаа бөгөөд нь уг нөөц нь хувьцаа хэлбэрээр байдаг ба энэхүү нөөц нь засгийн газрын байгууллагын олгосон бүрэн эрхийн дагуу газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн санаачлагаар байгуулсан хувийн компанийн мэдэлд байдаг байна.

➤ Болгар Улс

Болгарын улсын нөөцийг Улсын нөөц ба дайны үеийн нөөц гэж нэрлэдэг. Улсын нөөцийг Улсын нөөц ба дайны үеийн нөөцийн засгийн газрын агентлаг удирддаг. Уг байгууллага нь Улсын нөөц, дайны үеийн нөөцийг бүрдүүлэх, хадгалах, ашиглахтай холбогдсон бодлогыг үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд нийцүүлэн

хэрэгжүүлдэг байна.

Түүний үндсэн үүрэг нь:

- Улсын нөөц, дайны үеийн нөөцийг хуримтлуулах, хадгалах, шинэчлэх болон нягтлан бодох бүртгэлийг зохион байгуулах, хяналт тавих;
- Улсын нөөцийн нэрсийн жагсаалт, нормативыг батлуулахаар Сайд нарын зөвлөлд санал болгох;
- Улс орны цэрэг-аж үйлдвэрийн цогцолбор, дайчилгааны бэлтгэлтэй холбоотой асуудлаар Сайд нарын зөвлөл, Засгийн газар хоорондын зөвлөлд тайлагнах;
- Олон улсын хамтын ажиллагаа, Европ, Евро Атлантын интеграцын үйл ажиллагаанд оролцох;

Улсын нөөцийн нэр төрөлд:

- түлш
- химийн бодисууд
- хүнсний бүтээгдэхүүн
- хар ба өнгөт металл
- сэлбэг хэрэгсэл
- мод
- цаас
- эмнэлгийн бараа, эмнэлгийн хэрэгсэл
- цахилгаан хэрэгсэл багаж тоног төхөөрөмж орно.

Эдийн засгийн хүндрэлээс болоод жилд 45 сая еврог хэмнэх зорилгоор 2011 онд улсын нөөцийн 600 албан хаагчийг 39 болтол цөөрүүлж, улсын нөөц ба дайны үеийн нөөцийн тохируулагч агентлагийг татан буулгаж оронд нь Газрын тосны асуудал хариуцсан хэрэгжүүлэгч агентлагийг байгуулан зөвхөн газрын

тосны бүтээгдэхүүнийг нөөцөлж байхаар —Газрын тос ба тосны бүтээгдэхүүний тухайл хуульд өөрчлөлт оруулан —Улсын нөөц ба дайны үеийн нөөцийн тухайл хуулийг хүчингүй болгох талаар засгийн газрын шийдвэр гаргаж байжээ.¹⁰ Үүнээс болоод 2014 он гэхэд 3 сая тн байх ёстой эрдэст ус нэг ч литр байхгүй, шаардлагатай хэмжээний эмийн нөөцийн дөнгөж 1%, 90 хоногт хүрэлцэх хэмжээний үр тариа дөнгөж 30 хоногт хүрэлцэхээр, хүнсний бүтээгдэхүүний нөөцийн хангалт 17% байгаа талаар Болгарын сангийн яамны тайланд орж байжээ¹¹. Үүнийгээ улсын нөөцийн тоо хэмжээ өссөн, санхүүжилт хүрэлцэхгүй байгаатай холбон тайлбарлаж байв.

Харин 2020 оны 2 дугаар сарын 29-ны байдлаар Болгарын Засгийн Газраас коронавирусын халдвараас хамгаалахын тулд улсын нөөцөөс 100 мянган литр спирт гаргаж эмийн сангуудыг хангах шийдвэр гаргасан талаар тус улсын ерөнхий сайд Бойко Борисов мэдэгдсэн¹² талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн билээ. Энэ нь Болгарын улсын нөөц сэргэж, үүргээ зохих ёсоор гүйцэтгэж байгаагийн нэг жишээ юм.

Эндээс Болгар нь бүх төрлийн материаллаг нөөцтэй нь дээр ямар ч нөхцөлд шатахууны буюу газрын тосны бүтээгдэхүүний нөөцийг чухалчилж үздэг гэсэн дүгнэлтийг хийж болохоор байна. Удирдлагын хувьд зөвхөн газрын тосны бүтээгдэхүүний нөөцтэй байхад Тээврийн яаманд, олон нэр төрлийн нөөцтэй байхад Сангийн яаманд харъяалагдаж байгаа нь нөөцийн барааны төрлөөс хамаараад хаана ч харъяалагдаж болдгийг харуулж байна.

Харин улсын нөөцийн байгууллагын бүтэц, удирдлагыг хэрхэн хэрэгжүүлдэг талаар мэдээлэл алга байгаа тул энэ талаар дүгнэлт өгөх боломжгүй байв.

➤ Герман Улс

Газрын тосны хувьцаа эзэмших тухай хуулийн дагуу Гамбург хотод 1978 онд Газрын тос хадгалах холбоо гэдэг төрийн өмчийн корпорац анх байгуулагдсан нь Германы одоогийн улсын нөөцийн үүсэл болжээ¹³. Газрын тос хадгалах холбоо буюу Германаар EBV нь түүний газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн (бензин, дизель түлш, онгоцны буюу агаарын тээврийн төрөл бүрийн түлш)-ий 90-ээс доошгүй хоногийн нөөцийг хадгалж байх үүрэгтэй юм.

Харин дотооддоо газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг болон гаднаас импортолдог компаниуд заавал Газрын тос хадгалах холбооны гишүүн байх ёстой бөгөөд тус холбооны санхүүжилтэд заавал хувь нэмрээ оруулж байх ёстой байдаг.

Удирдлагын хувьд тус холбооны хоёр хүнээс бүрдсэн захирлуудын зөвлөлийг хяналтын байгууллага болох зөвлөлдөх зөвлөлөөс томилдог.

Зөвлөлдөх зөвлөл нь 9-өөс доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байдаг бөгөөд Холбооны эдийн засаг, эрчим хүчний яамнаас 1-3, Холбооны сангийн яам болон Холбооны зөвлөлөөс тус бүр 1, газрын тос үйлдвэрлэгчдээс 6 хүний төлөөлөлтэй байна. Газрын тос үйлдвэрлэгчдийн төлөөлөл нь тэдний нийтийн хурлаас 3 жилээр сонгогдоно. Зөвлөлдөх зөвлөлийн гишүүд нь нэг бол сонгогдоно, нэг бол томилогдоно.

Газрын тос хадгалах холбоо (EBV) нь эдийг засгийн болон хангалтын хороотой байна. Дээрх хороонууд нь тус холбооны гишүүн компаниудын төлөөлөгчдөөс бүрдэнэ. Холбооны удирдлага ба зөвлөлдөх зөвлөл нь эдгээр хороонуудад зөвлөх үүрэгтэй байдаг.

Эдийн засгийн хороо нь эдийн засгийн төлөвлөгөөний төсөл, татвараас ашиглагдаж байгаа хэмжээ, санхүүгийн жилийн тайлан зэргийг хянаж үзнэ. Түүнчлэн газрын тос хадгалах холбооны санхүүжилттэй холбоотой асуудлаар зөвлөгөө өгнө. Хангалтын хороо нь нөөц, түүний хэмнэлт, нөөцийн хэмжээ, хадгалалтын төлөвлөлт болон нөөцийн хэмжээг өсгөх, бууруулах асуудлаар зөвлөгөө өгнө. Нөөцийн удирдлагын гол хэлбэр нь логистик ба хувьцаа юм.

Удирдлагын гол үүрэг нь газрын тосны бүтээгдэхүүний хомстолд орсон тохиолдолд 90 хоног ашиглах нөөцтэй байлгахад оршино.

Газрын тос хадгалах холбооны материал техникийн хангалтын болон агуулахын салбарууд нь нөөцийн чанарыг алдагдуулахгүй хадгалах ажлыг зохион байгуулна.

Нөөцийг Германы бүх нутаг дэвсгэрийг хамарсан таван бүсийг хангаж байх зорилгоор доод тал нь 15 хоногийн нөөцтэй байхаар тараан байрлуулсан байх ёстой. Тус холбоо нь одоогоор 39.7 сая тн түүхий болон бэлэн газрын тосны бүтээгдэхүүний нөөцтэй байна. Хуульд заасны дагуу хувьцааны 90%-ийг өөртөө хадгалж байхын дээр зөвхөн 10%-ийг л төлөөллийн хэлбэрээр эзэмшиж болно¹⁴.

Үүнээс үзэхэд, ХБНГУ-ын улсын нөөц нь зөвхөн түүхий газрын тос болон боловсруулсан газрын тосны бүтээгдэхүүн байдаг бөгөөд төрийн өмчийн корпорацын мэдэлд байдаг. Нийт нөөцийн дөнгөж 10% -ийг бусад байгууллага хувьцаа хэлбэрээр эзэмшдэг. Нэгэнт 100% хувьцаанд хуваагдсан болохоор улсаас нэмэлт санхүүжилт шаарддаггүй. Корпорацын үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх, зардлыг багасгахын тулд логистик дээр тулгуурласан удирдлага явагддаг. Нөөцийг шаардлагатай үед жигд хүртээмжтэй хүргэж байхын тулд нутаг дэвсгэрийн хэмжээнд жигд тараан байрлуулсан зэрэг онцлогууд харагдаж байна. Мөн нөөцийн бүх байрлал, савны хэмжээг ямар ч нөхцөлд илрүүлэх боломжтой бөгөөд нийтэд ил байдаг учраас нууцлах шаардлагагүй гэж үздэг бололтой. Тиймдээ

ч улсын хэмжээнд байгаа нөөцийнхөө нийт хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр ил тод зарлаж байна.

➤ **Казахстан Улс:**

Казахстаны улсын нөөцийн байгууллага нь Казахстан улсын үндэсний эдийн засгийн яамны улсын материалын нөөцийн хороо юм. Уг хороо болон түүний харъя байгууллагуудаас улсын нөөцийн систем нь бүрддэг байна.

Казахстаны улсын нөөцийн зориулалт нь:

1. Дайчилгааны хэрэгцээг хангах,
2. Байгалийн болон техногенийн гаралтай гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, хар уршгийг арилгах эхний ээлжийн ажлыг хангах,
3. Хүмүүнлэгийн тусламж үзүүлэх,
4. Зах зээлд зохицуулах нөлөө үзүүлэх явдал байдаг.

Удирдлагын тогтолцооны хувьд Засгийн газар нь ерөнхий удирдлагын хэрэгжүүлдэг, төрийн захиргааны төв байгууллага нь улсын нөөцтэй холбоотой асуудлаарх эрх зүйн хэм хэмжээний актын биелэлтийг хангуулдаг, улсын нөөцийн байгууллагын удирдлага нь улсын нөөцийн системийн удирдлагыг хэрэгжүүлдэг байна. Үүнд:

Казахстан Улсын Засгийн Газар:

- улсын нөөцийн хөгжлийн нэгдсэн бодлогыг тодорхойлж, ерөнхий удирдлагаар хангах
- улсын нөөцийг байгуулж, түүний бүтцийг бий болгох
- улсын нөөцөөс бараа материал хасах болон зээлээр олгох шийдвэрийг гаргах
- улсын нөөцийн бараа, материалын нэр төрөл, тоо хэмжээг тогтоох
- шаардлагатай үед улсын төсвийн хөрөнгөөр улсын нөөцөд нэмэлт бараа материал авах тухай шийдвэр гаргах
- улсын нөөцийн үйл ажиллагаа явуулахтай холбогдсон дүрэм журмыг батлах
- улсын нөөц хадгалж байгаа объектуудын зардлыг нөхөн олгох, гамшиг ослын хор уршгийг арилгах, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, зах зээлийг тогтворжуулах зорилгоор гаргасан бараа материалыг нөхөн бүрдүүлэх журмыг тогтоох
- улсын нөөцийн бараа материал хадгалахад зориулсан объектыг барих байршуулах талаар шийдвэр гаргах.

Улсын нөөцийг хариуцсан төрийн захиргааны төв байгууллага (Үндэсний эдийн засгийн яам) өөрийн эрх мэдлийн хүрээнд:

- улсын нөөцийн хүрээнд Казахстан улсын эрх зүйн хэм хэмжээний актын гүйцэтгэлийг хангах
- улсын нөөцийн бараа материалын хадгалалтын талаар санал бэлтгэж, улсын нөөцөд бараа нийлүүлэх, хадгалахтай холбоотой гэрээ хэлэлцээр байгуулахад дэмжлэг үзүүлэх
- ~~- улсын нөөцөд бараа материал нийлүүлэх, байршуулах, хадгалахад зохион байгуулалтын дэмжлэг туслалцаа үзүүлэх~~
- улсын нөөцийн байгууллагатай тохиролцсоны үндсэн дээр бараа материалыг улсын нөөцөөс хасах, зээлээр олгох саналыг зохих журмын дагуу Засгийн газарт тавих.

Улсын нөөцийн байгууллага:

- улсын нөөцийн системийг удирдлагаар хангаж, улсын нөөцийн бараа материалыг байршуулах, хадгалах, нөхөн бүрдүүлэх, сэлгэх, шинэчлэх, зориулалтын

дагуу ашиглах үед нөөцийн тухай хууль, холбогдох бусад хэм хэмжээ эрх зүйн актыг мөрдөж ажиллах

- улсын нөөцийн бараа материалтай холбоотой үйл ажиллагаа явуулах холбогдох дүрэм журмыг боловсруулж, засгийн газраар батлуулахаар өргөн мэдүүлэх

- төрийн холбогдох байгууллагын оролцоотойгоор улсын нөөцийн бараа материалыг хадгалах хэм хэмжээ, нэр төрлийн талаар санал боловсруулж батлуулахаар Засгийн газарт өргөн мэдүүлэх

- улсын нөөцийн бараа материалыг бүрдүүлэх, хадгалах зардлын хэмжээ, бүтцийн талаар санал боловсруулж, засгийн газарт зохих журмын дагуу өргөн мэдүүлэх

- улсын нөөцөд бараа материал авах талаар захиалга өгөх, бараа материал авах болон шинэчлэхтэй холбоотойгоор бараа материал гаргах шийдвэр гаргах

- улсын нөөцийн бараа материал хадгалах байр татан буулгаж өөрчлөн зохион байгуулагдсан, зориулалт нь өөрчлөгдсөн тохиолдолд бараа материалыг шилжүүлэн байрлуулах талаар шийдвэр гаргах

- батлан хамгаалах хүрээнд дайчилгаанд бэлтгэх, дайчлах асуудлаар дайчилгааны нөөц хариуцсан байгууллагатай тохиролцож улсын нөөцийн бараа материал хадгалах байрны жагсаалтыг баталж, байгуулах

- улсын нөөцийн бараа материалыг хадгалах, шинэчлэх ажлыг хэрэгжүүлэх

- улсын нөөцийн бараа материалыг байршуулах, бүртгэл тооцоо хөтлөх

- хадгалалтын тоо, чанарт хяналт тавих, хяналт шалгалт хийх шийдвэр гаргах, үүндээ хууль тогтоомжийн дагуу мэргэжлийн байгууллага, хүмүүсийг татан оролцуулах, бараа материалын ашиглалт, хадгалалтын журам зөрчсөн хүмүүст хариуцлага тооцох талаар хууль хяналтын байгууллагад холбогдох материалыг илгээх

- улсын нөөцийн бараа материалтай холбоотой үйл ажиллагаанд оролцогчидтой хийсэн гэрээ хэлэлцээрээс үүдэлтэй зөрчлийг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх

- хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлэх гэж заасан байна.

Казахстаны улсын нөөц нь төсвийн санхүүжилт дээр тогтдог учраас үйл ажиллагааны зардал болон тогтолцоог боловсронгуй болгох, хадгалалт хамгаалалтын холбогдолтой зардлыг жил бүр төсөвлөж өгдөг байна. Казахстаны улсын нөөцийн нэг онцлог нь үл бууруулах нөөц нэртэй тодорхой тоо хэмжээнд

тогтмол барьж байдаг, тоо хэмжээ, ашиглах зарцуулах журмыг нь засгийн газраас тогтоож өгдөг тусгай нөөц байдаг. Нөөцийг шинэчлэх, зээлдүүлэх, нөөцөөс хасах журмыг хуулиар зохицуулсан байдаг ба хэрэгжүүлэх журмыг нь засгийн газрын тогтоолоор тогтоож өгдөг байна. Энэ бүгдээс үзэхэд Казахстаны улсын нөөц нь дайчилгааны бэлэн байдлыг хангах, гамшиг ослын үед эхний ээлжийн арга хэмжээ авах, зах зээлийг зохицуулах, хүмүүнлэгийн тусламж үзүүлэхэд чиглэгдсэн байдаг ба дайчилгааны нөөцийг Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатайгаа хамтран збхион байгуулдаг, хатуу тогтоосон үл хөдлөх нөөцтэй, шинэчлэлтээс бусад тохиолдолд нөөцөөс бараа гаргах асуудлыг Засгийн газрын шийдвэрийн дагуу шийдвэрлэдэг, улсын нөөцийн байгууллага нь Үндэсний эдийн засгийн яамандаа харъяалагддаг зэрэг онцлогтой байна.

➤ **Украин Улс:**

Украины улсын нөөцийн байгууллага нь сайд нарын танхимаас зохицуулагддаг, Эдийн засгийн хөгжил, худалдааны яаманд захирагддаг Украины нөөцийн тохируулагч агентлаг юм. Даргыг нь эдийн засгийн хөгжил, худалдааны сайдын санал

болгосноор Ерөнхий сайд өргөн мэдүүлж засгийн газар томилдог байна. Улсын нөөц нь үр тариа хүлээн авах, хадгалах, боловсруулах, гурил үйлдвэрлэх, агуулахын болон хөргөх байгууламжаар тоноглогдсон, газрын тосны бүтээгдэхүүн хадгалах объектууд бүхий гуч гаруй үйлдвэрийн газартай юм.

Улсын нөөц нь 1991 оны 11 дүгээр сарын 01-нд байгуулагдсан, 1992 онд Улсын материаллаг нөөцийн тухай дүрэм, Украйны материаллаг нөөцийн улсын хорооны дүрэм зэргийг Украйны сайд нарын танхим батлан гаргасан. 1993 онд улсын нөөцийн бараа материалын нэр төрөл, бүрдүүлэх түвшнийг баталсан. 1997 онд Улсын материаллаг нөөцийн тухай хууль батлан гаргасан.

Уг хуульд зааснаар улсын нөөц нь:

- ❖ бараа материалын үл бууруулах нөөц – байнга тогтоосон тоо хэмжээнд байлгаж, хадгалдаг нөөц,

- ❖ дайчилгааны нөөц – цэргийн болон бусад үйлдвэрлэлд болон дайны үед бүх төрлийн тээвэр, холбоо, хий, газрын тос, цахилгаан усан хангамж, эмнэлгийн тусламжийг тасалдалгүй байлгах, цэргийн техник хэрэгслийг засварлахад зориулсан материал техникийн болон түүхий эдийн нөөц,

- ❖ улсын стратегийн хэрэгцээг хангахад зориулсан түүний эд, материал техник, хүнсний нөөц,

- ❖ гамшиг ослын үед эхний ээлжийн арга хэмжээ авахад болон хууль тогтоомжид заасан бусад арга хэмжээг авахад зориулсан материал техникийн нөөц зэргээс бүрддэг байна.

Улсын нөөцийн зориулалт нь:

- дотоодын зах зээлд төдийгүй олон улсын гэрээ, хэлэлцээрийг биелүүлэхэд эрэлт, нийлүүлэлтийн харьцаа алдагдсан, түүний эд, түлш эрчим

хүчний нөөц, хүнсний чухал шаардлагатай төрлийн хангалтын хугацаа зөрчигдсөн тохиолдолд эдийн засгийг тогтворжуулах зорилгоор үйлдвэр аж ахуйн газрууд, улс ардын аж ахуйн салбаруудыг төрөөс дэмжлэг үзүүлэх,

- хүмүүнлэгийн тусламж үзүүлэх,
- гамшиг ослын хор уршгийг арилгах үеийн эхний ээлжийн ажлыг хангах.

Украйны улсын нөөцийн нэгдсэн систем нь түүний удирдлагын системийн үндэс болдог. Уг системийг Украйны сайд нарын танхим бий болгодог бөгөөд тэр тогтолцоонд ордог улсын нөөц, үйлдвэр аж ахуйн газар, албан байгууллагуудын удирдлагыг улсын нөөцийг бүрдүүлэх, хадгалах, үйлчлэх ажлыг зохион байгуулах, нийгмийн хөгжлийг хангах чиг үүрэг бүхий гүйцэтгэх засаглалын төв байгууллага хэрэгжүүлнэ гэж хуулиндаа заажээ.

Улсын нөөцийн системийн бүтэц, улсын нөөцийг удирдах журмыг Украйны сайд нарын танхим тодорхойлдог байна. Улсын нөөц нь түүний байршил, улсын нөөцийн системд ордог үйлдвэр, аж ахуйн нэгж, албан байгууллага, тэдгээрийн байрлаж байгаа газраас үл хамааран улсын өмч байх ба ямар ч тохиолдолд хувьчлагдахгүй байхаар хуульчлагдсан байна.

Улсын нөөцийн системд багтдаг үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага нь улсын онцгой объект тул тэдгээрийн хамгаалалт, галын аюулгүй байдлыг цэрэгжсэн хамгаалалтын байгууллага хариуцдаг. Гүйцэтгэх засаглалын төв байгууллагатай гэрээгээр ажиллаж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагууд өмчийн хэлбэрээс үл хамааран улсын нөөцийн системд ордоггүй. Украйны улсын нөөцийн удирдлагын тогтолцоо ба үүрэг:

Улсын нөөц, түүний дотор үл бууруулах нөөцөд байх бараа материалын нэр төрөл, тэдгээрийн тоо хэмжээг Украйны сайд нарын танхим баталдаг.

Улсын болон үл бууруулах нөөцийн нэр төрлийн талаар санал боловсруулах, тэдгээрийг нөхөн бүрдүүлэх журмыг улсын нөөц хариуцсан гүйцэтгэх засаглалын төв байгууллага тогтооно. Харин дайчилгааны нөөцийг сайд нарын танхимын тодорхойлсон үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага дээр өмчийн хэлбэр харгалзахгүйгээр батлан хамгаалах яам, эдийн засгийн бодлогын асуудал хариуцсан гүйцэтгэх засаглалын төв байгууллага, улсын нөөцийн удирдлагыг хэрэгжүүлдэг бусад байгууллагатай зөвшилцөн байгуулна. Жил бүр улсын нөөцийн бараа материал нийлүүлэх хэмжээг сайд нарын танхим баталж, баталсан хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр нийлүүлнэ. Шаардлагатай тохиолдолд түүнчлэн олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу сайд нарын танхимын шийдвэрээр батлагдсан хэмжээнээс илүүгээр захиалж, нийлүүлж болно.

Санхүүжилт нь улсын төсвөөс гадна үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын аж ахуйн үйл ажиллагаанаас олсон нэмэлт санхүүжилт байж болно. Борлуулалтын орлогыг бараа материалыг нөхөн бүрдүүлэхэд зарцуулна.

Үйл ажиллагааны зардал, хэвийн хорогдол, үнийн алдагдал, хадгалалтын зардал зэргийг улсын төсвөөс болон улсын нөөцөөс хасагдсан бараа материалын борлуулалтаас санхүүжүүлнэ. Жил бүр үндсэн хөрөнгийн барилга байгууламж барих, өөрчлөн зохион байгуулах, улсын нөөцийн системийг боловсронгуй болгох, эрдэм шинжилгээ, туршилт зохион бүтээлтийн ажил явуулахад зориулсан санхүүжилтийг улсын төсвөөс хийнэ.

Улсын нөөцийн байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгоход чиглэсэн эдийн засгийн урамшууллын системтэй байдаг.

Хуулиараа:

- улсын нөөцийг шинэчлэх,
- зээлдүүлэх,
- жагсаалтаас хасах,
- хүмүүнлэгийн тусламж үзүүлэх,
- гамшиг, ослын хор уршгийг арилгах,
- бусад онцгой нөхцөл бий болсон үед бараа материалыг зөвхөн сайд нарын танхимын зөвшөөрлөөр гаргана.

Харин улсын нөөцийн бараа материалыг борлуулахдаа дуудлага худалдааны зарчмыг баримталдаг байна.

Ийнхүү Украйны улсын нөөцийн бүтэц, зохион байгуулалт, удирдлага нь хуучин социалист системийн орнууд болон ОХУ-ын Улсын нөөцтэй төстэй байна.

Энд байгаа нэг онцлог нь улсын нөөцийн бараа материал нь ихэвчлэн түүхий эд хэлбэрээр байх бөгөөд улсын нөөцийн системд зөвхөн хадгалалт хамгаалалт хариуцсан байгууллага бус үйлдвэр аж ахуйн нэгж, байгууллага багтдаг. Улсын нөөцийн бүрэлдэхүүнд үл бууруулах нөөц гэж байдаг. Улсын нөөцийн байгууллагын тогтолцоонд зөвхөн төрийн өмчийн байгууллага багтдаг. Харин гэрээгээр үүрэг гүйцэтгэж байгаа байгууллагууд улсын нөөцийн байгууллагын тогтолцоонд багтдаггүй.

Улсын нөөцийн бараа материал бүрдүүлэх болон үйл ажиллагааны зардал, тэрч байтугай хэвийн хорогдлыг нөхөх зардал улсын төсвийн хөрөнгөөр санхүүждэг байна.

➤ АНУ:

АНУ-ын үндсэн санхүүгийн нөөц нь Холбооны нөөцийн сан хэмээх санхүүгийн нөөц юм. Тогтолцооны хувьд тэр нь 90 000 салбар, 371 000 автомат теллер машинтай дэлхийн хамгийн том банкны систем юм. Холбооны нөөцийн сан нь 12 хүний бүрэлдэхүүнтэй Холбооны нээлттэй зах зээлийн хороо (Federal open market committee)-ноос бүрддэг. Эдгээр гишүүд урт хугацаагаар сонгогддог тул улс төрийн нөлөөнд автах нь тун бага байдаг.

Холбооны нөөцийн сан нь эдийн засгийн болон үнийн тогтвортой байдлыг хангах, инфляцыг хязгаарлах, ажилгүйдлийн түвшний өсөлтийг барих үүрэгтэй бөгөөд энэ зорилгоор гишүүдийг удаан хугацаагаар сонгодог.

Эдийн засаг болон үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор банкнуудын зээлийн хэмжээ, хүүнд нөлөөлөх, үнэт цаас худалдах, банкнуудын хүүгийн түвшинг богино хугацаанд удирдах, мөнгөний нийлүүлэлтийг хянах ажиллагаа явуулдаг. Гурван үндсэн чиг үүрэгтэй:

1. Засгийн газрын үнэт цаасыг худалдан авах худалдах,
2. Заавал байх нөөц буюу үл хөдлөх нөөцийг тогтоосон хэмжээнд байлгах,
3. Зээлийн хүүгийн бодлогыг барих.

Өөрөөр хэлбэл Америкийн улсын санхүүгийн нөөц нь үндсэндээ мөнгө санхүүгийн асар их нөөц байдаг бөгөөд түүгээрээ эдийн засгаа тогтворжуулж, хямралаас хамгаалж байдаг. Энэ дэлхийд эдийн засгаараа тэргүүлдэг том гүрний нөгөө талаар төрийн байгууллын хувьд улсуудын холбооны тогтолцоотой улсын нэг өвөрмөц онцлог юм.

Үүнээс гадна хүнсний аюулгүй байдлыг хангах үүднээс газар тариалан эрхлэлтийг дэмжих байгалийн баялгаа хамгаалах, үр тарианы улсын нөөцийг бий болгох талаар онцгой анхаарч 1979 онд хүнсний аюулгүй байдлын тухай хууль, 1986 онд хүнсний аюулгүй байдлыг сайжруулах тухай хуулийг тус тус батлан гаргажээ¹⁵ АНУ-ын хүнсний цогцолбор нь хамгийн их хамгаалагдсан цогцолбор бөгөөд хөдөө аж ахуйн түүхий эдээр үйлдвэрлэсэн хүн амын хүнсний болон бусад хэрэгцээг хангах зорилготой хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх салбарууд (үйлдвэрүүд)-ын цогц буюу улс орны газар тариалангийн үйлдвэрлэлийн цогцолбор юм¹⁶.

Уг цогцолбор нь байгалийн нөөцөө хадгалж, хөдөө аж ахуйгаа дэмжсэний үндсэн дээр хүн амын хүнсний хангамжийг тогтвортой байлгахад чиглэсэн хэмжээний тусгай актыг мөрдөж ажилладаг байна. Эдгээр хэм хэмжээний актад дээрх хуулиуд зүйл ёсоор ордог билээ. 1979 оны хуулийн дагуу улс орны дотоодын хүнсний аюулгүй байдлыг хангаад зогсохгүй бусад оронд хүнсний тусламж үзүүлэх зорилгоор улсын нөөцдөө үр тариаг нөөцөлдөг байна. Энэ хүрээнд 2008 онд манай улсад 25 мянган тн улаан буудай өгч байсан билээ. 1986 оны хууль нь хөрсний үржил шимийг хамгаалах, Америкийн фермүүдийг дэмжих системийг улам бэхжүүлсэн юм. Эдгээр хуулиудыг батлан гаргасан нь Холбооны ²⁰тусгай хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ юм. Түүнчлэн газрын тосны болон онцгой байдлын үеийн нөөцтэй байдаг.

Үүнээс үзэхэд, Америкийн улсын нөөцийн систем нь хэрэгцээтэй үед хэрэглэхээр нөөцлөхөөс гадна аюулгүй байдлыг хангах, хүн амын хүнсний хангалтыг тогтвортой байлгах, газрын тосны хомстлоос хамгаалах угтвар нөхцөлийг хангахад чиглэсэн бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд чиглэдэг байна. Бусад орнуудаас ялагдах нэг том онцлог нь газрын тос бүхий талбайг

нөөцлөх, үр тариа, хүнсний ногоо тарих үржил шимтэй газрыг нөөцөлдөг явдал юм.

➤ **БНХАУ:**

БНХАУ нь үр тарианы дэлхийн хамгийн том үйлдвэрлэгч бөгөөд хамгийн том хэрэглэгч юм. Тийм учраас улсын нөөцийн зонхилох хэсгийг үр тариа эзэлдэг. Үр тарианы нөөцөд ихээхэн анхаарч шинээр орчин үеийн тоног төхөөрөмж бүхий агуулах барьж, байгуулах, агуулахыг автоматжуулж, механикжуулж, агааржуулах, температур тохируулах, халдваргүйжүүлэх, ариутгах төхөөрөмжөөр тоноглох асуудлыг бүрэн шийдвэрлэж байгаа ч гэсэн зөвхөн үр тарианы агуулахад 196 мянган хүн ажиллаж байгаа нь ямар их хэмжээний нөөцтэй болон үүндээ ямар их анхаарч байгааг харуулж байна.

Үүнээс гадна бусад төрлийн хүнсний, эрүүл мэндийн, газрын тосны бүтээгдэхүүн, орон сууцны нөөцийг бий болгосон төдийгүй, нөөцийн бараа материалын төрөл, чиглэл тус бүрд зориулсан сургалт, эрдэм шинжилгээ судалгааны болон технологийн шинэчлэлийн төрийн болон төрийн бус байгууллагууд ажиллаж байна. БНХАУ-д шинжлэх ухаан технологийн реформ хийж байгаатай холбогдуулан эрдэм шинжилгээ судалгааны ашгийн бус нэгдсэн төв академи байгуулан ажиллуулж байна. Энэ нь үндсэндээ хүнсний аюулгүй байдал, эрүүл мэнд, хүнс, үр тариа болон газрын тосны бүтээгдэхүүнээр бүтээгдэхүүн үйлдвэрлэх асуудлыг боловсруулах, шинжилгээ судалгааны шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, эрдэм шинжилгээ судалгаа, туршилт зохион бүтээлтийн ажил явуулах зэрэг хүрээг хамарсан нийгмийн ашгийн бус төслүүдийг хариуцдаг байна. Урьд нь засгийн газрын мэдэлд байсан эрдэм шинжилгээний таван хүрээлэнг шинжлэх ухаан технологийн реформын хүрээнд өндөр технологийн корпорац болгон өөрчилсөн бөгөөд орон нутгийн хэмжээнд мужуудын 27 эрдэм шинжилгээний хүрээлэн ажиллаж үр тарианы боловсруулалт, хадгалалт, хуваарилалтад үр ашигтай чанарын хяналт тавин ажиллаж байна.¹⁷

Түүнчлэн түүхий газрын тосыг газрын тосны бүтээгдэхүүнээс тусад нь нөөцөлдөг, гамшгаас хамгаалах нөөцийг Иргэний хэргийн яамандаа харъяалуулдаг, бусад нөөц нь улсын хөгжил, шинэчлэлтийн яамандаа харъяалуулсан зэрэг улсын нөөц нь бусад орноос онцлог зохион байгуулалттай байна. *Дээрх байдлаас дүгнэж үзэхэд хэдийгээр том үйлдвэрлэгч ч гэсэн хэрэгцээнийхээ хэрээр нөөц бүрдүүлж, түүнийгээ улам боловсронгуй болгохын тулд маш том эрдэм шинжилгээ, туршилт судалгааны байгууллагуудыг ажиллуулж, улсын нөөцийн бараа бүтээгдэхүүнд тогтмол чанарын хяналт тавьж байгаа нь зарим орны улсын нөөцөөс нэлээд онцлогтой бөгөөд зайлшгүй авч хэрэгжүүлүүштэй туршлага, сургамж мөн юм. Улсын гол нөөц нь улс орны тогтвортой хөгжил, хөгжил шинэчлэлтэд чиглэгдсэн байдаг учраас Улсын хөгжил шинэчлэлтийн яамандаа улсын нөөц нь харъяалагддаг. Гамшгаас хамгаалах нөөц нь хүн амын аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий Иргэний хэргийн яамандаа харъяалагддаг нь нөөцийн удирдлагыг үр ашигтай болгох чухал механизм болсон байна.*

➤ **Оросын Холбооны Улс**

ОХУ-ын улсын нөөцийн удирдлага нь холбооны улсын нөөцийн төв аппарат, орон нутгийн байгууллагууд (Алс дорнодын, Приволжскийн, Сибирийн, Баруун хойт бүсийн, Уралын, Төвийн, өмнөд бүсийн), харъя байгууллагууд (төрийн өмчит байгууллага болох мэдээлэл, тооцоолон бодох ерөнхий төв, төсвийн байгууллага болох Улсын нөөцийн хадгалалтын асуудал эрхэлсэн эрдэм шинжилгээний хүрээлэн,

сургалтын төсвийн байгууллага болох Улсын нөөцийн коллеж), улсын нөөцийн бараа материалын хадгалалтыг хариуцдаг төрийн өмчит байгууллагууд зэргээс бүрдэнэ.

Төв аппарат нь:

- ❖ захиргааны удирдлагын газар,
- ❖ улсын нөөцийн газар,
- ❖ санхүү эдийн засгийн газар,
- ❖ дайчилгааны нөөцийн газар,
- ❖ төрийн бараа материал худалдан авалт, хэрэгжүүлэлтийн газар,
- ❖ улсын батлан хамгаалах захиалгыг бүрдүүлэх, гүйцэтгэх газар,
- ❖ эрх зүй, санхүүгийн дотоод аудитын газар,
- ❖ улсын нууц хамгаалалтын газар,
- ❖ барилгын хөрөнгө оруулалт, ашиглалтын газар,
- ❖ дайчилгааны бэлтгэлийн газар зэргээс бүрддэг. Агентлаг нь

дараах бүрэн эрхийг хэрэгжүүлдэг. Үүнд:

1. Үйл ажиллагааныхаа эрхлэх ажлын хүрээнд улсын болон орон нутгийн бараа, ажил, үйлчилгээг худалдан авах хэрэгцээг хангахын тулд бараа, ажил, үйлчилгээг худалдан авах тухай ОХУ-ын хууль, тогтоомж, бусад эрх зүйн хэм хэмжээний актыг хэрэгжүүлж ажиллах,

2. Агентлагийн үйл ажиллагааны эрхлэх асуудлын хүрээнд хамрах хууль болон эрх зүйн бусад баримт бичиг (Ерөнхийлөгч болон засгийн газраас батлан гаргадаг) - ийн төслийг ОХУ-ын засгийн газарт өргөн мэдүүлэх,

3. Холбооны хууль, Засгийн газрын актаар тогтоосон журам тэдгээрийн хүрээнд ОХУ-ын нөөцийн бүрэлдэхүүн хэсэг болсон улсын материаллаг нөөц, энэ талаарх төрийн үйлчилгээтэй холбоотой болон улсын нэгдсэн үйлдвэрийн газар, холбооны төрийн байгууллага, агентлагийн харъяа газруудад шилжүүлэн өгсөн өмчийн өмчлөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх,

4. Үйл ажиллагааныхаа хүрээнд хамрах асуудлаар холбооны үндсэн хууль бусад хууль, ерөнхийлөгчийн болон засгийн газрын холбогдох актуудын үндсэн дээр хэм хэмжээний актыг бие даан гаргах,

5. Дараах асуудлыг зохион байгуулах:

- Тогтоосон журмын дагуу улсын материаллаг нөөцийн бараа материалыг бүрдүүлэх, байршуулах, хадгалах, үйлчилэх, тэдгээрийн цэрэгжсэн хамгаалалт,

- Тогтоосон журмын дагуу улсын материаллаг нөөцийн бараа материалын бүрэн бүтэн байдал, хөдөлгөөн, тоо хэмжээний хяналт

6. Дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх:

- Улсын материаллаг нөөцийн системийг удирдах,

- Улсын материаллаг нөөцийг тогтоосон журмын дагуу цаг тухайд нь шинэчилж байх,

- Улсын материаллаг нөөцөөс зээлээр авсан бараа материалыг тогтоосон цаг хугацаанд нь буцаан авах, зарцуулагдсан нөөцийн бараа материалыг нөхөн бүрдүүлэх,

- Дайчилгааны нөөцөөс бусад улсын нөөцийн бараа материалын хадгалалтын нөхцөл, хугацааг тогтоох,

- Өмчлөх эрхтэй холбоотой заалтад байгаа эд хөрөнгө болон улсын нууцад хамаарах мэдээллийн бүртгэл тооцоог хөтлөх,

- Агентлагийн орон нутгийн байгууллагууд болон харъяа байгууллагуудын үйл

ажиллагаанд хяналт тавих.

7. Харъяа улсын үйлдвэрийн газруудын үйл ажиллагаанд эдийн засгийн шинжилгээ хийж, тэдний үйл ажиллагааны эдийн засгийн үзүүлэлтүүдийг баталж өгөх, харъяа байгууллагууддаа санхүү аж ахуйн үйл ажиллагаа болон хөрөнгийн ашиглалтад хяналт шалгалт хийх,

8. Агентлагийн үйл ажиллагааны хүрээнд холбооны зорилтот, шинжлэх ухаан, техник, инновацийн төсөл хөтөлбөрийн улсын захиалагчийн үүргийг хэрэгжүүлэх,

9. Агентлагт оногдсон үүргийг хэрэгжүүлэх, агентлагаас үйл ажиллагаагаа явуулахад зориулсан холбооны төсвийн хөрөнгийн гол хуваарилагч, хүлээн авагчийн үүргийг гүйцэтгэх,

10. Иргэдийг хүлээн авах ажлыг зохион байгуулах, иргэдийн амаар болон бичгээр ирүүлсэн санал гомдлыг цаг тухайд нь бүрэн хянаж тэдгээртэй холбоотой шийдвэрийг гарган хууль тогтоомжид заасан хугацаанд өргөдөл гаргагчид хариуг өгөх,

11. Өөрийн эрх мэдлийн хүрээнд улсын нууцад хамаарах мэдээллийг хамгаалах арга хэмжээ авах,

12. Агентлагийн дайчилгаа болон дайчилгааны бэлтгэлийг зохион байгуулж, хангах, түүнчлэн дайчилгааны бэлтгэл явуулдаг харъяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж зохицуулах,

13. Агентлагт иргэний хамгаалалтын ажлыг зохион байгуулж явуулах ажлыг хэрэгжүүлэх,

14. Агентлагийн төрийн албан хаагчдын мэргэжлийн боловсролын нэмэлт сургалтыг зохион байгуулах,

15. Сургалтын болон агентлагийн харъяа байгууллагын даргад нэр дэвшигчид ба дээр дурдсан байгууллагын дарга нарыг аттестатчилах хугацаа, журмыг тогтоох ,

16. Нэрэмжит тэтгэлэг бий болгох, түүнийг олгох нөхцөл, хэмжээг тодорхойлох,

17. Тогтоосон журмын дагуу гадаад орнуудын төрийн байгууллага болон олон улсын байгууллагуудтай үйл ажиллагааныхаа чиглэлээр харилцах,

18. Агентлагийн үйл ажиллагааны явцад бий болсон архивын баримт бичгийг ОХУ-ын хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэх, хадгалах, бүртгэх, ашиглах,

19. Холбооны хууль тогтоомж, Ерөнхийлөгч, Засгийн газрын хэр зүйн хэм хэмжээний актад заасан бусад бүрэх эрхийг эрхлэх ажлынхаа хүрээнд хэрэгжүүлэх,

20. Эрхлэх үйл ажиллагааныхаа чиглэлээр эрх мэдлээ хэрэгжүүлэх зорилгоор Холбооны улсын нөөцийн агентлаг нь **дараах эрхийг эдэлнэ:**

- Агентлагийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар хуулийн этгээд, хувь хүмүүст тайлбар өгөх;

- Өөрийн үйл ажиллагааны хамрах хүрээний асуудлыг боловсруулах, шинжлэн судлахад эрдэм шинжилгээний болон бусад байгууллага, эрдэмтэд мэргэжилтнүүдийг зохих журмын дагуу татан оролцуулах,

- Өөрийн эрхлэх үйл ажиллагааны хүрээнд зөвлөл, комисс, бүлэг, зөвлөлдөх бүлэг зэрэг зөвлөх болон шинжээчдийн баг байгуулах,

- ОХУ-ын хууль тогтоомжийн дагуу тогтоосон журмын дагуу "Хөдөлмөрийн ахмад зүтгэлтэн" цол, тэмдэг болон байгууллагын бусад шагнал бий болгох, төв, орон нутгийн болон харъяа байгууллагын ажилтан, түүнчлэн өөрийн эрхлэх үйл ажиллагааны хүрээнд үйл ажиллагаа явуулдаг бусад хүмүүсийг шагнах, эдгээр тэмдэг, шагналын тухай журам, тэдгээрийн тайлбарыг батлах.

21. ОХУ-ын Ерөнхийлөгчийн зарлиг, ОХУ-ын Засгийн газрын тогтоолоор

тогтоосон тохиолдлоос бусад тохиолдолд Холбооны Улсын нөөцийн агентлаг нь хяналт, шалгалтын чиг үүргийг хэрэгжүүлэх эрхгүй.

ОХУ-ын улсын нөөцийн удирдлага зохион байгуулалтыг судалж үзэхэд холбооны улсын нөөц нь:

- Улс орны тогтвортой хөгжлийг хангах,
- Нийгэм эдийн засгийн бүхий л салбарыг хөгжүүлэхэд чиглэгдсэн,
- Улсын нөөцийн удирдлагыг боловсронгуй болгох механизмыг бүрдүүлсэн,
- Улсын нөөцийн чанар, үр ашгийг дээшлүүлэх, зардлыг багасгахад

дөхөмтэй,

▪ Өргөн уудам нутаг дэвсгэрт цаг алдалгүй нэгэн зэрэг хүртээмжтэй ажиллах боломжтой,

▪ Төлөвлөлт, хяналтын систем нь оновчтой зэрэг удирдлага, зохион байгуулалтын давуу тал ихтэй байна.

Ялангуяа улсын нөөцийн байгууллагын бүтцийн нэгжүүд, албан тушаалтны үндсэн чиг үүргийг эрх зүй хэм хэмжээний актаараа маш нарийн зааж өгсөн нь улсын нөөцийн удирдлага үр ашигтай шуурхай явагдах механизмыг бүрдүүлэх нэг нөхцөл болсон байна. Түүнчлэн хяналт арга, механизм нь улсын нөөцийн бараа материалын тоо, чанарыг тогтоосон хэмжээнд барьж байх чухал нөхцөлийг бүрдүүлжээ. Улсын нөөцийн удирдлагын гол аргыг логистикийн арга гэж үзэж үүнийг улсын нөөцийг удирдах үйл ажиллагаандаа тууштай нэвтрүүлсэн байна. Улсын нөөцийн удирдлагын чанар, үр өгөөжийг дээшлүүлэх гол хөшүүрэг нь тэдгээрийг боловсронгуй болгоход чиглэсэн эрдэм шинжилгээ судалгааны ажил бөгөөд үүнд лабораторийн туршилт шинжилгээг өргөн ашиглаж байгаагийн дээр улсын нөөцийг хөтөлж явуулах, удирдах хүний нөөцийг мэргэжлийн сургуулиар бэлтгэж байгаа нь улсын нөөцийг мэргэжлийн удирдлагаар тасралтгүй хангаж байх чухал механизм болсон байна.

Дүгнэлт

Гадаад орнуудын улсын нөөц, түүний удирдлагад хийсэн шинжилгээнээс нэгдсэн дүгнэлт хийж үзэхэд:

Нөөцийн бараа материалыг дараах зориулалтаар нөөцөлдөг байна. Үүнд:

- Улс орны эдийн засгийн аюулгүй байдлыг хангах,
- Өргөн хэрэглээний бараа, материалын хомстлоос сэргийлэх,
- Зах зээлийн савалагааг тогтворжуулах,
- Гадаад улс оронд тусламж үзүүлэх,
- Өөрийн орны нутаг дэвсгэрт байгаа байгалийн баялгийг хамгаалах, хойч үедээ

үлдээх,

- Өөрт байгаа баялгаа шаардлагатай үед санхүүгийн нөөц болгон хувиргах,
- Гамшиг ослын үед эхний²⁴ арга хэмжээ авахад шаардлагатай бараа

материалыг нөөцлөх зэрэг зорилгоор улсын нөөцийг бүрдүүлдэг байна.

Нэр төрлийн хувьд гол төлөв газрын тосны бүтээгдэхүүн, үр тариа, байгалийн хий, нүүрс зэргийг стратегийн нөөц болгож, хүнсний түгээмэл нэр төрлийн бараа, бүтээгдэхүүн, өөрт үйлдвэрлэдэггүй импортоор авдаг техник, тоног төхөөрөмж, түүний сэлбэг хэрэгсэл, хөнгөн хийцийн түр орон сууц, эм бэлдмэл, ороох, боох материал зэргийг нөөцөлж байна.

Нөөцийн бараа, материалын нэр, төрөл, тоо хэмжээ, байршил нь тухайн улс орны хөгжил, эдийн засгийн чадавх, байгалийн баялгийн нөөцийн хэмжээ, экспорт,

импортын гол нэр төрөл, зах зээлийн эрэлт хэрэгцээ, төрийн байгууламж, нөөцийн зориулалт зэргээс шалтгаалаад янз бүр байна. Тухайлбал,

Нөөцийн хэлбэр агуулга нь улс орны төрийн байгууламжаас хамаараад өөр өөр байх явдал ч байна.

Нэгдмэл улсын хувьд ихэвчлэн улсын хэмжээний нэг нэр төрлийн бүтээгдэхүүний нэг нөөцтэй, түүний удирдлага нь төвлөрсөн хэлбэртэй байна.

Холбооны улсын хувьд ихэвчлэн ерөнхий төвлөрсөн нэг удирдлагатай, нөөц нь бүрэлдэхүүн субъектүүддээ байдаг бөгөөд тус тусын удирдлагатай байдаг.

Харин улсуудын холбооны хувьд ихэвчлэн улс бүр өөр өөрийн нөөцтэй, түүндээ тохирсон удирдлагатай байдаг бөгөөд холбооны нөөц нь 1-2 төрлийн стратегийн төвшний бараа бүтээгдэхүүн байдаг ба холбооны хэмжээнд удирдлага явуулдаг бүтэцтэй байна.

Тухайлбал, АНУ нь бусад улсын нэгэн адил санхүүгийн болон материалын гэсэн нөөцийн хоёр төрөлтэй боловч санхүүгийн нөөц нь төвлөрсөн төдийгүй гадаад улс орнуудад тусламж үзүүлэх, материаллаг нөөц нь дотоодын хүнсний аюулгүй байдлыг хангах, газрын тосны хомстлоос хамгаалах зорилготой байдаг ба бэлэн бүтээгдэхүүнээс гадна газрын тосны талбай, тариалангийн үржил шимтэй газрын нөөцөлдөг.

Тэгвэл хуучин социалист системд хамаарагдаж байсан төрийн байгууламж нь нэгдмэл улс орнуудын хувьд ихэвчлэн эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, зах зээлийг тэнцвэржүүлэх зорилго бүхий материалын болон санхүүгийн гэсэн нөөцийн хоёр төрөлтэй байна.

Улсуудын холбооны бүрэлдэхүүнд байдаг ХБНГУ гэхэд европын холбооны улсуудыг газрын тосны бүтээгдэхүүнээр хангах хэмжээний газрын тосны бүтээгдэхүүний нөөцтэй байна.

Инфляц ба ажилгүйдэл бага, өндөр технологитой, ашигтай үйлдвэрлэлтэй, ажиллах хүчний ур чадвар сайтай Дани мэтийн улс батлан хамгаалах нөөцөөс гадна ахуйн хэрэгцээнд болон үйлдвэр үйлчилгээнд зориулж газрын тос, байгалийн хийг нөөцөлдөг байна.

Бенин зэрэг буурай хөгжилтэй улс эдийн засгийг тогтворжуулах, зах зээлд нөлөөлөх хүчин чадал дутмаг учраас гамшиг ослын үед хүн амаа хамгаалахад л гол анхаарлаа хандуулж улсын нөөц гэж нэрлэгдэх гамшгаас хамгаалах нөөц бүрүүлдэг.

Газрын тос, байгалийн хийн асар их нөөцтэй Иран зөвхөн газрын тос, байгалийн хийн улсын нөөцийг, газрын ховор элемент ихтэй Япон газрын ховор элементийн нөөцийг бүрдүүлж байгаа нь дэлхийн зах зээлд хамгийн их эрэлт хэрэгцээтэй, өндөр үнэтэй байгаа түүхий эд бүтээгдэхүүнийг шаардлагатай үед санхүүгийн эх үүсвэр болгох зорилгоор нөөцөлдөг болохыг харуулж байна.

АНУ, Франц, БНХАУ гэх мэт өөртөө байгаа баялгийн нэр төрлийг импортоор их хэмжээгээр авч байгаа нь байгалийн баялгаа нөөц болгон хадгалж байгаагийн нэг жишээ юм.

Байгалийн болон хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй гамшиг осол их гардаг улс орнууд улсын нөөцөөс гадна гамшгаас хамгаалах нөөцтэй байдаг гэх мэт дүгнэлтүүдэд хүрлээ.

Гадаад улс орнуудын улсын нөөц, түүний удирдлагын талаар судалж үзэхэд нөөцийн төрөл, хэлбэр, зориулалт өөр, өөр байгаагаас үүдээд удирдлага нь харилцан адилгүй байдаг явдал ажиглагдаж байна.

Улсын нөөцийг зарим улс оронд улсын төсвийн санхүүжилтээр санхүүждэг төрийн байгууллагууд удирдаж байхад, зарим улс оронд төрийн өмчийн корпорацууд, зарим улс оронд хувийн хэвшлийн байгууллагууд засгийн газартай хийсэн гэрээний дагуу удирдаж байна.

Зарим улс оронд улсын нөөцийг нэг байгууллага төвлөрүүлэн удирдаж байхад, зарим улс оронд нөөцийн бараа, материалын төрлөөс хамаараад төрөл бүрийн яам, агентлагууд төрөлжүүлэн удирдаж байна.

Харин улсын нөөц нь хаана харъяалагдаж байгаагаас үл хамааран улсын нөөцийн зорилго, удирдлагын үүрэг нь үндсэндээ адил байна.

Тухайлбал,

Улсын нөөц нь тухайн улсын эдийн засгийг тогтворжуулах, аюулгүй байдлыг хангах, зах зээлийг тэнцвэржүүлэх, гамшиг ослоос хамгаалах зэрэг нийтлэг зорилготой байна.

Судалгаанаас үзэхэд улсын нөөцийн байгууллагын удирдлагын нийтлэг үүрэг нь:

- Улсын нөөцийн талаар төрөөс баримтлах бодлогын үндсийг боловсруулж, батлуулах, хэрэгжүүлэх

- Улсын нөөцийг бүрдүүлэх, байршуулах, хадгалах, хамгаалах, ашиглах, нөхөн бүрдүүлэх, үйлчлэх ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, зохицуулах, хянаж шалгах, хүний нөөцийг бүрдүүлэх явдал юм.

Энэ бүгдээс үзэхэд улсын нөөцийн үүрэг зорилго, улсын нөөцийн удирдлагын тогтолцоо, үүрэг тухайн улсын төрийн байгууламж, хөгжлийн түвшин, байгалийн нөөц, баялаг, хүн амын хэрэгцээ, гамшиг ослын нөхцөл байдал зэргээс шууд хамааралтай болох нь харагдаж байна.

Иймд Монгол Улсын нөөцийн төрөл, хэлбэр, зорилго, түүний удирдлагын үүрэг, зорилтыг олон улсын жишигт нийцүүлж шинжлэх ухааны үндэстэй тодорхойлж, цаашид боловсронгуй болгохын тулд улсын нөөц ба түүний удирдлагын өнөөгийн байдалд шинжилгээ хийж Гадаадын зарим орны улсын нөөц, түүний удирдлагад хийсэн шинжилгээтэй харьцуулан дүгнэлт хийх замаар улсын нөөцийн бүтэц, тогтолцоо, удирдлагыг боловсронгуй болгох арга замыг сайжруулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Ашигласан материал, эх үүсвэрийн жагсаалт

1. Монгол Улсын нөөцийн тухай хууль
2. Б.Амаржаргал, Б.Мөнхжаргал, Менежмент, УБ, 2013 он.
3. Д.Болормаа , —МенежментII, Улаанбаатар хот, 2001 он
4. Д.Ганбаатар бусад, —МенежментII, Улаанбаатар хот, 2017он
5. Л.Наранцэцэг, Стратегийн менежмент, УБ, 2012 он.
 6. Н.Наранцэцэг, —Монгол МенежментII, Улаанбаатар хот, 2003 он
 7. Ч.Пүрэвдорж, —Менежментийн УдирдлагаII, Улаанбаатар хот, 2002 он
 8. Н.Цэнд Н, Г.Батхүрэл , ..Ц. Цэцэгмаа нар —МенежментII 2013 он, УБ

Цахим эх үүсвэр:

9. <https://mn.wikipedia.org/wiki/Бенин>
10. <https://ru.wikipedia.org/wiki/Дания>
11. <https://ru.wikipedia.org/wiki/китай>
12. https://ru.wikipedia.org/wiki/новая_Зеландия
13. <https://ru.wikipedia.org/wiki/франция>
14. https://www.rosreserv.ru/Konsultativnij_sovet
15. <https://www.sagess.fr/en/profile/about-sagess/overview>
16. <https://www.sagess.fr/en/profile/about-sagess/cpssp>
17. <https://www.blackseanews.net/read/27995>
18. <http://www.novinite.ru/articles/>
19. <https://rg.ru/2020/02/29/v-bolgarii-iz-gosrezerva-vydelili-100-tys-litrov-spirta->
20. <https://www.ebv-oil.org/cms/cms2.asp?sid=57&nid=&cof=57>
21. <https://www.ebv-oil.org/cms/cms2.asp?sid=60&nid=&cof=60>
22. https://www.rosreserv.ru/Konsultativnij_sovet/Obmen_opitom/Sozdanie_
23. <https://konspekts.ru/ekonomika-2/ekonomika-apk/prodovolstvennyj-kompleks->
24. https://www.rosreserv.ru/Konsultativnij_sovet/Obmen_opitom/Sozdanie_i_razvitiye_sistem_materialnogo